



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

Б.Гүрсоронзонг ажилд томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01/2796 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2019 оны 05/4531 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан Буянтотгохын Гүрсоронзонг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар томилсугай.

2.Б.Гүрсоронзонтой контрактыг холбогдох хууль, журмын дагуу байгуулж, хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хууль зүйн хэлтэс (А.Ариунболд)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000453